



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР, “МОНГОЛЫН СУРАГЧДЫН ХОЛБОО” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2017 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 3.

Улаанбаатар
хот

Монгол Улсад Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллах, энэхүү үйл ажиллагаанд иргэд олон нийтийг хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжих зорилгоор нэг талаас Авлигатай тэмцэх газар /цаашид Авлигатай тэмцэх газрын УССГХ гэх/, нөгөө талаас “Монголын Сурагчдын холбоо” Төрийн бус байгууллага /цаашид МСХ гэх/ харилцан тохиролцож “Санамж бичиг”-ийг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь Монгол Улсад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллах, төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах, шат дамжлагыг цөөрүүлэх, ил тод нээлттэй болгох, энэхүү үйл ажиллагаанд иргэд олон нийтийг хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжихэд оршино.
- 1.2. Талууд хамтын ажиллагаанд хараат бус, хууль дээдлэх, харилцан бие биенээ хүндэтгэх, мэргэшсэн, тогтвортой байх зарчмуудыг баримтална.

Хоёр. Хамтын ажиллагааны хамрах хүрээ

2.1. Соён гэгээрүүлэх чиглэлээр:

- 2.1.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг “Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх;
- 2.1.2. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр ном, тохимол, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн, сурталчилгааны материал, зурагт хуудас зэргийг боловсруулах, тараах;

2.1.3. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр богино хэмжээний кино, шторкийн бүтээх ажлыг хамтран зохион байгуулах, олон нийтийг авлигын эсрэг үзэл хандлагад уриалсан аян, акц хөдөлгөөн үүсгэн зохион байгуулах.

2.2. Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- 2.2.1. Нийгмийн аль ч давхаргад байгаа авлигын шалтгаан нөхцлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, таслан зогсоох арга замыг олон нийтийн оролцоонд тулгуурлан тодорхойлох арга хэмжээг үе шаттай хамтран хэрэгжүүлэх, үр дүнгийн талаар олон нийтэд тайлагнах.
- 2.2.2. Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах, шат дамжлагыг цөөрүүлэх, хяналт, үнэлгээ, мониторингийн болон нөлөөллийн үйл ажиллагааг улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулж, хамтран хэрэгжүүлэх.

Гурав. Санхүүгийн дэмжлэг

3.1. Талуудын авч хэрэгжүүлэх аливаа ажил, арга хэмжээ нь санамж бичгийн хүрээнд төлөвлөсөн хөтөлбөр, төлөвлөгөөнний дагуу зохион байгуулагдах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хоёр тал тухай бүр харилцан тохиролцсоны дагуу АТГ-аас хариуцан шийдвэрлэнэ.

Дөрөв. Нэмэлт өөрчлөлт оруулах

4.1. Санамж бичигт талуудын бичгээр гаргасан зөвшилцлийн үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Аль нэг тал нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт гаргасныг үндэслэн өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл, хоёр талын төлөөлөгчид зөвшилцэж нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичигт гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Тав. Санамж бичиг хүчин төгөлдөр болох

5.1. Талууд нь гарын үсэг зурснаар энэхүү Санамж бичиг хүчин төгөлдөр болно. Санамж бичиг нь 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг дүгнэсэний дараа харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаа сунгана.

Зургаа. Хүчингүй болгох

6.1. Санамж бичгийг цуцлах талаар талууд бичгээр мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор харилцан тохиролцсоны үндсэн дээр цуцалж болно.

Долоо. Талуудын нэр, бэлгэ тэмдгийг хэрэглэх

- 7.1.1. Аль нэг Талын нэр, товчилсон нэр, бэлгэ тэмдэг, албан ёсны тамга, тэмдгийг хамтын ажиллагаатай холбогдуулан хэрэглэхийн тулд эрх бүхий албан тушаалтнаас урьдчилан зөвшөөрөл авна.
- 7.1.2. Талууд энэхүү Санамж бичгийн хүрээнд хэвлүүлсэн сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн, сурталчилгааны хэвлэмэл материал, нэвтрүүлэг, шторк зэргийг өөрөөр тохиролцоогүй бол Авлигатай тэмцэх газрын өмчид тооцно.
- 7.1.3. Хамтын ажиллагааны явцад олж авсан аливаа мэдээллийг улс төрийн болон бусад зорилгоор ашиглах, дамжуулахыг хориглоно.
- 7.1.4. Талууд харилцан ойлголцож гарын үсэг зурж баталгаажуулав.

ТАЛУУД:

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

төлөөлж:

Урьдчилан сэргийлэх
гэгээрүүлэх хэлтсийн соён
эрхэлсэн комисар дарга,

№ 0-22-5120829

/Т.БАЯРХҮҮ/

МОНГОЛЫН СУРАГЧДЫН ХОЛБОО
ТӨРИЙН БУС БАЙГУУЛАГА

төлөөлж:

Ерөнхий нарийн бичгийн дарга



/Г.ТӨГСӨӨ/

№ 0-22-5120829 + 1116228304